



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОНХС-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ИРГЭДИЙН САНАЛААР
ДЭМЖИГДЭЭГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗӨРЧИЛ ДАВТАГДАН ГАРСААР БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ДАА-2025/31-07-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дархан-Уул аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayars@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsuren@audit.gov.mn

Ахлах аудитор С.Санжаажав

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70373089 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Аудитор Ч.Гантулга

Утас: 70373089 Цахим хаяг: gantulgach@audit.gov.mn

Аудитор З.Мөнгөнцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

Аудитор Ч.Болормаа

Утас: 70378845 Цахим хаяг: bobmaach@audit.gov.mn

Аудитор Н.Хулансүрэн

Утас: 70378845 Цахим хаяг: khulansuren@audit.gov.mn

Аудитор Г.Золбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: zolbayarg@audit.gov.mn

АГУУЛГА

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал.....	6
БҮЛЭГ 1: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, АЙМГИЙН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ ОЛГОСОН БАЙНА	9
1.1. ОНХНС-аас Дархан-Уул аймагт ОНХНС-аас 20,763.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоо батлагдсанаас 20,023.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 739.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу хуваарилсан байна.....	9
1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.	9
1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж олгосон байна.	10
1.1.3. Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.	11
1.1.4. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөсөн байна.	11
1.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого чиглэлд уялдуулсан хэдий ч иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, саналаар дэмжигдээгүй ТАХ-г хэрэгжүүлэх зөрчил давтагдан гарсаар байна.	12
1.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй байна.	12
1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй байна.....	13
1.2.3. Иргэдийн саналаар дэмжигдээгүй 10 төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.....	14
1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгажээ.	14
БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА	16
2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримталж ажиллажээ.	16
2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАУХАТ хуулийн дагуу зохион байгуулсан байна.	16
2.1.2. Гэрээнд заасан тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй байхад Дархан сумын ОНХС-аас 16.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компанид олгожээ.	18
2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 97.6 хувьтай байна	20
2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5 ТАХ төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй байна.	20
2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгөх ТАХ 98.0 хувийг эзэлж байна... ..	20
БҮЛЭГ 3: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА	25
3.1 Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг дутуу хөтлөх зөрчил давтан гарч байна. 25	25
3.1.1 Дархан сумын ИТХ “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4-т заасан дагуу хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	25
3.1.2. “ДХББЗГ” ОНӨААТҮГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хууль, журмын дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ.	25
3.1.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан ч алдаа, зөрчил давтагдан гарч байна.	26
3.2.2 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн 1,503.5 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	27
3.2.3 ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг УМС-д бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт үнэн зөв бодитой мэдээллээр хангаагдахгүй байна.	28
3.2.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ОНХС-ийн орлогын 2,218.0 сая төгрөгийн 11 гүйлгээ, зарлагын 261.3 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.	29
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар:	30
ДҮГНЭЛТ: 31	31
ЗӨВЛӨМЖ: 32	32

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДХББЗГ	Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УМС	Удирдлагын мэдээллийн сан
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт	8
Хүснэгт 2	Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн гүйцэтгэл	8
Хүснэгт 3	Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарь, хуваарьт орсон өөрчлөлт, гүйцэтгэл	10
Хүснэгт 4	ОНХС-ын хөрөнгийн эх үүсвэр	10-11
Хүснэгт 5	Санал өгсөн иргэдийн тоо	12
Хүснэгт 6	Тендер шалгаруулалтын байдал	15
Хүснэгт 7	Хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт	17
Хүснэгт 8	Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ТАХ-ний жагсаалт	25-26

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХНС-аас олгосон санхүүжилт улирлаар	9
Дүрслэл 2	ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ	14
Дүрслэл 3	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ны 2023-2024 оны харьцуулсан үзүүлэлт	20
Дүрслэл 4	Иргэдээс авсан асуулгын дүн	21
Дүрслэл 5	УМС-д мэдээлэл оруулсан байдал (ТАХ-ны тоо)	27

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Дархан-Уул аймаг Шилэн дансанд мэдээлээгүй ТАХ	26
Хавсралт 2	Орхон сум Шилэн дансанд мэдээлээгүй ТАХ	29

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;*

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны Засаг дарга, аймаг, Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын ОНХС-ийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, иргэд, гүйцэтгэгч ААН-ийн үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Санжаажав, аудитор Б.Алтанзул, Ч.Гантулга, З.Мөнгөнцэцэг, Ч.Болормаа, Н.Хулансүрэн, Г.Золбаяр нар гүйцэтгэсэн.



Аудитын тайлан баталгаажуулсан тушаал



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 2/31

Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Аудитын тайланг Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга А.Янжмаа, Засаг дарга Б.Азжаргал, Дархан сумын ИТХ-ын дарга Б.Эрдэнэзаяа, Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын Засаг дарга нарт болон Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Бат-Эрдэнэ, “ДХББЗГ” ОНӨААТҮГ-ын дарга Д.Батбаяр нарт хүргүүлэхийг аудитын баг (ахлах аудитор С.Санжаажав)-т даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан сумын ИТХ-ын дарга (Б.Эрдэнэзаяа), Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын Засаг дарга нарт болон Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Бат-Эрдэнэ), “ДХББЗГ” ОНӨААТҮГ-ын дарга (Д.Батбаяр) нарт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгч, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын баг (ахлах аудитор С.Санжаажав)-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Батсүрэн)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МЭНХБАЯР



4525010092

D:\Bichig hereg\2025\Tushaal.docx

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн /31/ дугаар тушаалын хавсралт



Аудитаар өгсөн төлбөрийн актын жагсаалт

(мянган төгрөг)

Д/д	Төлбөр, зөрчил хариуцах байгууллага	Зөрчлийн товч утга	Дугаар	Төлбөрийн актын дүн
1	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийн тохижилт" төслийн төсөв, гүйцэтгэлийг шалгахад автомашины зогсоол барих ажлыг 3,537,700.00 төгрөгөөр дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг олгосон байна.	02/116-A0970284-ДАА-2025/31-7-ШТА-ГА	3,537.7
2	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Лэд Сити" ХХК-ийн 1,108,349,335.00 төгрөгөөр гүйцэтгэсэн "Сумын төвийн гэрэлтүүлэг" -ийн төсөв, гүйцэтгэлийг шалгахад 3 нэр төрлийн тоног төхөөрөмжийн төсвийг зах зээлийн үнээс 5,150,000.00 төгрөгөөр өндөр төлөвлөж, санхүүжилт авсан байна.	04/118-A0970284-ДАА-2025/31-7-ШТА-ГА	5,150.0
3	Дархан сумын Засаг дарга	Дархан сумын ЗДТГ нь 3 дугаар цэцэрлэгт 18,114,000.00 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж худалдан авахдаа тус бүр нь зах зээлийн ханшаас 500,000.00 төгрөгөөр өндөр үнэтэй 2 телевизор худалдан авч, "Эрдэнэ завилаа" ХХК-д нийт 1,000,000.00 төгрөг илүү төлсөн байна.	01/115-A0960289-ДАА-2025/31-7-ШТА-ГА	1,000.0

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

Д/д	Төлбөр, зөрчил хариуцах байгууллага	Зөрчлийн товч утга	Дугаар	Албан шаардлагын дүн
1	Орхон сумын Засаг дарга	Захиалагч "Орхон сумын төвийн хороолол доторх замыг хатуу хучилттай болгон засварлах" 30,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зураг төсөв", "Орхон суманд 2025 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах" 55,532,800 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудын худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим хуудаст байршуулаагүй шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.	11/116-A0970287-ДАА-2025/31-7-ШТА-ГА	85,532.8
2	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Лэд Сити" ХХК-ийн 1,108,349,335.00 төгрөгөөр гүйцэтгэсэн "Сумын төвийн гэрэлтүүлэг" ажлын төсөв, гүйцэтгэлийг шалгахад гэрэлтүүлгийн шон дугаарлах, дамжуулагчийн унжилтыг хэмжих, тохируулах, газардуулгын эсэргүүцэл хэмжүүлэх, будах зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр өгсөн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврыг биелээгүй байна.	10/115-A0970284-ДАА-2025/31-7-ШТА-ГА	-
3	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	"Өнөр зам" ХХК-ийн гүйцэтгэсэн Од цогцолбор сургуулийн Б байрны авто замын шинэчлэлтийн ажлын хүрээнд хийгдсэн явган хүний замд эвдрэл үүссэн байна.	02/107-A0960289-ДАА-2025/31-7-ШТА-ГА	-
4	Хонгор сумын Засаг дарга	Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Чонос хүч" ХХК-ийн гүйцэтгэсэн 19,991,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй "Камержуулалт, засварлах" төслийн гүйцэтгэлийг шалгахад хүлээн авсан 32 камерын 20 камер эвдэрч ажиллахгүй болсон байна.	08/113-A0970284-ДАА-2025/31-7-ШТА-ГА	19,991.0

5	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Эрдэнэдрилинг" ХХК-ийн гүйцэтгэсэн "Зулзагын амралтын бүсэд худаг гаргах" ажлын хүрээнд 84,431,805.00 төгрөгөөр гүйцэтгэсэн 2 гүний худгийн дээд худгаас ус гарахгүй болж, зуслангийн айлуудын хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.	09/114-A0970284-ДАА-2025/31-7-ШТА-ГА	
6	Хонгор сумын Засаг дарга	"Зулзагын амралтын бүсэд худаг гаргах" ажлын гүйцэтгэлийг шалгахад доод худаг нь эрүүл ахуйн хориглолтын бүсээс дотогш буюу бие засах газрын хажууд баригдсан нь иргэдийн эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй байна.	07/112-A0970284-ДАА-2025/31-7-ШТА-ГА	
7	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	Шарын гол сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Болор Эрхэст Цамхаг" ХХК-ийн гүйцэтгэсэн "Авто зам дагуух гэр хороолол руу ногоон байгууламж, явган зам тавих" ажлын хүрээнд хийгдсэн ногоон байгууламжийн хашаанд 40 ширхэг нарс мод тарих хэсэгт навчит мод тарьсан нь техникийн тодорхойлолтод заасантай нийцэхгүй байна.	06/111-A0971292-ДАА-2025/31-7-ШТА-ГА	
8	Шарын гол сумын Засаг дарга	Шарын гол сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Тоталсолушн" ХХК-ийн гүйцэтгэсэн "Сумын доторх авто замын хяналтын камерын засвар, шинэчлэл" ажлын хүрээнд 16 цэгт байршуулсан камерын 10 цэгт нь камер хэвийн ажиллаж үлдсэн 6 камер холболт салснаас ажиллахгүй байна.	03/108-A0971292-ДАА-2025/31-7-ШТА-ГА	
9	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	"Нарсан цамхаг" ХХК-ийн 201,393,212.00 төгрөгөөр гүйцэтгэсэн Орхон сумын Тосгон Богчийн дэв, Дэлгэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтын ажлын хүрээнд хийсэн сүлжээний төхөөрөмж бүрэн хүчин чадлаараа хэвийн ажиллахгүй байгаагаас камерын бичлэг тасалдаж байна.	05/110-A0971312-ДАА-2025/31-7-ШТА-ГА	
10	Орхон сумын Засаг дарга	"Софт солар энерги" ХХК-ийн 19,850,000.00 төгрөгөөр гүйцэтгэсэн Орхон сумын өвсний агуулах засварлах ажлын хүрээнд хийсэн өвсний агуулахын том хаалганы бэхэлгээ, 2 талын амлагаа хийгдээгүй, дээрээс ус алдсан байна.	04/109-A0971312-ДАА-2025/31-7-ШТА-ГА	
11	"ДХББЗГ" ОНӨААТҮГ	"Нарт Оргил Өргөө" ХХК-ийн гүйцэтгэсэн "Шарын гол сумын нэг маягийн сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбайн тохижилтын ажил"-ын 1 сандал, 5 хогийн сав эвдэрсэн, сагсны талбайн будаг халцарсан байдалтай байна.	06/106-A0971282-ДАА-2025/31-7-ШТА-ГА	

БҮЛЭГ 1: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, АЙМГИЙН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ ОЛГОСОН БАЙНА

1.1. ОНХНС-аас Дархан-Уул аймагт 20,763.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 20,023.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 739.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу хуваарилсан байна.

1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлжээ.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Дархан-Уул аймгийн ОНХС-д 19,834.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан ба 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр оруулсан өөрчлөлтөөр санхүүжилтийг 929.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 20,763.4 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр тогтоолоор ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас 19,092.4 сая төгрөг, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, ОНХНС-ийн гүйцэтгэлийн урамшууллаас 1,671.1 сая төгрөг, өмнөх оны шилжих хөрөнгө оруулалтын үлдэгдлээс 4,150.0 сая төгрөг, нийт 24,913.5 сая төгрөгийн санхүүжилтээр бүрдүүлэхээр баталсан байна.

Хүснэгт №1: Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт (сая. төг)

№	Аймаг, сумдын нэр	ОНХНС болон улсын төсвөөс		Өмнөх оны үлдэгдлээс	Нийт эх үүсвэр
		ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг	Гүйцэтгэлийн урамшуулал		
1	Дархан-Уул аймаг	7,610.3	-	1,946.7	9,557.0
2	Дархан сум	3,390.7	542.4	678.6	4,611.7
3	Хонгор сум	5,415.1	564.6	983.2	6,962.9
4	Орхон сум	727.9	171.9	298.5	1,198.3
5	Шарын гол сум	1,948.4	392.2	243.0	2,583.6
	Нийт дүн	19,092.4	1,671.1	4,150.0	24,913.5

Эх сурвалж: Сангийн яам, аймгийн СТСХ

Гүйцэтгэлээр 2024 онд ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс 20,023.6 сая төгрөг, малын тоо, толгойн албан татвараас 357.2 сая төгрөг тус тус төвлөрч нийт 20,380.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлснээр орлогын төлөвлөгөө 94.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт №2: Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн гүйцэтгэл (сая. төг)

№	Аймаг, сумын нэр	ОНХНС болон улсын төсөв		Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр		Нийт эх үүсвэр	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Дархан-Уул аймаг	7,610.3	7,770.9		-	7,610.3	7,770.9
2	Дархан сум	3,933.1	4,406.9	10.0	-	3,943.1	4,406.9
3	Хонгор сум	5,979.7	4,800.7	250.0	250.0	6,229.7	5,050.7

4	Орхон сум	899.8	857.1	77.2	77.2	977.0	934.3
5	Шарын гол сум	2,340.5	2,188.0	30.0	30.0	2,370.6	2,218.0
	Нийт дүн	20,763.4	20,023.6	367.2	357.2	21,130.7	20,380.8


Эх сурвалж: Сангийн яам, аймгийн СТСХ

Сумдын ОНХС-д малын тоо толгойн албан татварт 367.2 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр Дархан сумын малын тоо толгойн албан татварын 10.0 сая төгрөгийн орлогоос бусад татварын орлого бүрэн төвлөрсөн байна.

1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж олгосон байна.

Сангийн яам нийт орлогын шилжүүлгийн 17.9 хувийг I улиралд, 26.9 хувийг II улиралд, 27.9 хувийг III улиралд, 27.3 хувийг IV улиралд шилжүүлжээ. Сангийн яам аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн сар улирлын хуваарийг баталж гаргасан боловч гүйцэтгэлээр зөвхөн нэгдүгээр улирлын санхүүжилтийг хуваарийн дагуу олгож, бусад саруудад олгох санхүүжилтийг хуваарийн дагуу шилжүүлээгүй байна. Үүнд II улирлын санхүүжилтийг 0.4 хувиар, III улирлын санхүүжилтийг 1.1 хувиар, IV улирлын санхүүжилтийг 10.8 тус тус дутуу санхүүжүүлсэн байна.

Дүрслэл №1: ОНХНС-аас олгосон санхүүжилт улирлаар



Энэ нь төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, улирлын шинж чанартай төсөл, арга хэмжээнүүд дараа онд шилжих, төсөвт өртөг өсөх эрсдэлийг бий болгож байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3¹ дэх заалт, Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу Дархан-Уул аймагт хуваарилсан 20,763.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс 7,610.3 сая төгрөг буюу 36.6 хувийг аймгийн ОНХС-д, 13,153.1 сая төгрөг буюу 63.4 хувийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

Орлогын шилжүүлгийг сумдын хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ болон ашигт малтмал, газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнд үндэслэн хамгийн их буюу 28.8 хувийг Хонгор суманд, үүнээс 6.7 дахин бага дүнгээр Орхон суманд тус тус хуваарилахаар баталжээ.

ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу тооцож хуваарилсан бол олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээ, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогоос хамаарч харилцан адилгүй хуваарилсан байна.

¹ “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно”

1.1.3. Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгожээ.

Аймгийн Засаг дарга 2023 онд 01-А/369 тоот захирамжаар баталсан ОНХС-ийн 2024 оны төсвийн хуваарийг 2024 оны 01-А/196 тоот захирамжаар 2,203.3 сая төгрөгөөр, 2024 оны 01-А/467 тоот захирамжаар 2,760.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

Хүснэгт №3: Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарь, хуваарьт орсон өөрчлөлт, гүйцэтгэл (сая. төг)

Санхүүжилт						
Улирал	Сумын нэр	Анх баталсан хуваарь 01-А/369	Эхний өөрчлөлт оруулсан хуваарь 01-А/196	Хоёр дахь өөрчлөлт оруулсан хуваарь 01-А/467	Гүйцэтгэл	Зөрүү
1	2	3	4	5	6	7=6-5
I	Дархан	338.1	635.9	635.9	261.1	(374.8)
	Хонгор	513.1	1,155.4	1,155.4	392.5	(762.9)
	Орхон	77.5	149.0	149.0	59.9	(89.1)
	Шарын гол	201.6	383.3	383.3	155.6	(227.7)
II	Дархан	520.8	1,599.4	1,599.4	1,171.9	(427.5)
	Хонгор	790.4	1,949.3	1,916.9	1,834.6	(82.3)
	Орхон	119.5	495.9	495.9	305.4	(190.5)
	Шарын гол	310.5	495.9	589.9	516.9	(73.0)
III	Дархан	1,384.7	950.5	1,116.1	1,380.1	(264.0)
	Хонгор	2,101.3	1,327.8	1,633.4	1,189.2	(444.2)
	Орхон	317.6	222.6	258.2	365.3	(107.1)
	Шарын гол	825.6	690.8	690.8	902.0	(211.2)
IV	Дархан	1,523.9	1,260.3	1,260.3	1,593.8	(333.5)
	Хонгор	2,312.7	2,268.1	2,257.3	1,634.4	(622.9)
	Орхон	349.6	295.1	295.1	203.7	(91.4)
	Шарын гол	908.7	919.5	919.5	643.5	(276.0)
ДҮН		12,595.6	14,798.9	15,356.4	12,609.9	(2,746.5)

Эх сурвалж: Аймгийн СТСХ

Хүснэгтээс харахад батлагдсан хуваарийн дагуу 2,746.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй нь гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосонтой холбоотой байв.

1.1.4. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын ИТХ нь Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2-т² заасны дагуу 2024 онд ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг 20,763.4 сая төгрөгийг ОНХС-аас, 367.2 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж, 4,150.1 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт №4: ОНХС-ын хөрөнгийн эх үүсвэр (сая.төг)

№	Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	эзлэх хувь
1	ОНХС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	19,026.1	75.3
2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	0.7	0.0
3	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	65.6	0.3

² “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ”

4	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал	1,671.1	6.6
5	ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	4,150.1	16.4
6	Малын тоо толгойн татвар	367.2	1.5
ДҮН		25,280.8	100.0

Эх сурвалж: Дархан-Уул аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийн 75.3 хувийг ОНХС-аас олгох орлогын шилжүүлгээр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3³-т заасан эх үүсвэр буюу олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшууллыг сумдын 2023 оны ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан 1,671.1 сая төгрөгийг олгосон байв.

Дээрхи урамшууллын 2024 оны гүйцэтгэлийг сумдаар авч үзвэл Шарын гол сум 40.5 хувиар үнэлэгдэж хамгийн өндөр урамшуулал авч ОНХС-ийн эх үүсвэрээ нэмэгдүүлсэн байхад Дархан сум 18.7 хувь буюу хамгийн бага үнэлгээтэй байна.

Дархан-Уул аймаг мал тооллогын дүнгээр 2022 онд 313,213 тоо мал, 2023 онд 261,286 толгой тоолуулсан нь өнгөрсөн оноос 51,927 толгой малаар буюу 16.6 хувиар буурчээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сум нь сумын ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор малын тоо толгойд ногдуулах татварыг тогтоохдоо үхэрт 1,000 төгрөг, бусад малыг 2,000 төгрөгөөр, бусад сумууд бүх малд 2,000 төгрөг байхаар тогтоосон байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд малын тоо толгойн татвар 367.2 сая төгрөгөөр төсөвлөснөөс аймгийн Татварын газрын 2024 оны мэдээгээр 359.0 сая төгрөгийн малын тоо толгойн татвар төлөгдсөн байна.

1.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого чиглэлд уялдуулсан хэдий ч иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, дэмжигдээгүй ТАХ-г хэрэгжүүлэх зөрчил давтагдан гарсаар байна.

1.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй байна.

Аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагч нар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1⁴-д заасны дагуу санал асуулгыг цахим, бүлгийн ярилцлага, саналын хуудас зэргээр авч, эрэмбэлжээ.

Аймгийн хэмжээнд иргэдийн санал өгсөн 468 ТАХ-г эрэмбэлж, 23,000.5 сая төгрөгийн 88 ТАХ-г баталсан байна.

Төсвийн тодотголоор иргэдийн санал өгсөн 200 ТАХ, санал аваагүй 10 ТАХ-г нэмж, нийт 22,700.8 сая төгрөгийн 210 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталжээ. Үүнээс аймагт 7,180.6 сая төгрөгийн 32 ТАХ, сумдад 15,520.2 сая төгрөгийн 178 ТАХ-г тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын хэмжээнд сонгуулийн насны иргэдийн 39.9⁵ хувь нь ОНХС-д санал өгсөн бол Дархан-Уул аймгийн хэмжээнд 11,571 иргэнээс санал авсан нь сонгуулийн насны

³ “Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа орон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг”

⁴ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

⁵ Эх сурвалж 1212.mn, onhs.mof.gov.mn

иргэдийн 16.1 хувийг эзэлж байна. Үүнд сонгуулийн насны иргэдийн 10.9 хувийг Дархан сум, 13.4 хувийг Орхон сум тус тус хамруулсан нь дундаж хувийг буурахад нөлөөлжээ.

Аймгийн хэмжээнд санал өгсөн иргэдийн дундаж хувийг өнгөрсөн онтой харьцуулахад 3.2 хувиар өссөн хэдий ч улсын дунджаас 23.8 хувиар бага байгаа нь ОНХС-д өгөх иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй болохыг харуулж байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5: Санал өгсөн иргэдийн тоо

№	Өрхийн тоо	Сонгуулийн насны хүн амын тоо	ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд санал өгсөн иргэд	
			Тоо	Хувь
Шарын гол сум	1,954	5,177	1,547	29.9
Хонгор сум	1,525	4,024	3,151	78.3
Орхон сум	1,003	2,276	306	13.4
Дархан сум	26,300	60,335	6,567	10.9
Дүн	30,782	71,812	11,571	16.1

Эх сурвалж: ОНХ-ийн эрэмбэлсэн жагсаалт, холбогдох баримт, 1212.тп

Санал өгсөн иргэдийн тоог сонгуулийн насны иргэдийн тоотой харьцуулахад Дархан сум хамгийн бага буюу иргэдийн 10.9 хувийг хамруулсан бол Хонгор сум үүнээс 7.2 дахин их хэмжээний иргэнийг хамруулсан нь иргэдээс санал авах ажил сумдад харилцан адилгүй байна.

Дархан сумын санал өгсөн иргэдийн тоо хамгийн бага хувийг эзэлж байгаа нь баг бүрийн сонгуулийн насны оршин суугчдын тоог харгалзан үзэлгүйгээр баг тус бүрийн 250 иргэнээс санал авах ажлыг зохион байгуулснаас шалтгаалжээ.

Иймд Дархан, Орхон сумын Засаг дарга болон багийн удирдлагууд санал асуулгад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн олон сувгийг ашиглах, хуулийг сурталчлан таниулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2⁶, 63.3⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1⁸, 4.3.1⁹-т заасны дагуу аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 46 хувь нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи болон дэд бүтэц, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, авто замын засвар, шинэчлэлт, гэрэлтүүлэгт, 38 хувь нь орчны тохижилт, ногоон байгууламж, зураг төсөв боловсруулахад, 16 хувь нь ундны усан хангамж, мал аж ахуй, ажлын байр бий болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-д чиглэгджээ. Эдгээр нь Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, мөн аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны

⁶ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

⁷ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ.

⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

⁹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

мөрийн хөтөлбөрийн хөгжлийн бодлогын үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.

1.2.3. Иргэдийн саналаар дэмжигдээгүй 10 төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг аудитад хамруулан шалгахад тухайн орон нутгийн иргэдийн саналыг аваагүй 10 төсөл, арга хэмжээг баталсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6¹⁰, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 4.3.2¹¹-д заасантай нийцэхгүй байна. Тухайлбал

Дархан сумын ОНХС

- Аймгийн Прокурорын газрын барилгын гадна засварт 20.0 сая төгрөг,
- “Дархан-Ус суваг” ХК-нд тусгай зориулалтын автомашин худалдан авахад 216.5 сая төгрөг,

Шарын гол сумын ОНХС

- 2 дугаар сургуулийн урлаг заалны шал засварлахад 15.0 сая төгрөг,
- “Тулга” сувиллын сувилуулагчдын ор, тумбочек шинэчлэхэд 14.0 сая төгрөг,
- Сумын доторх авто замын хяналтын камерын засвар, шинэчлэлд 100.0 сая төгрөг,
- Хот тохижуулах хэсгийн албан хэрэгцээнд хог тээвэрлэх авто машин худалдан авахад 28.0 сая төгрөг,
- Зохиомол хээлтүүлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 18.8 сая төгрөг,
- Сум дундын цагдаагийн хэлтэст автомашин худалдан авахад 23.5 сая төгрөг,
- Дрон худалдан авахад 4.8 сая төгрөг,
- Сум дундын Цагдаагийн хэсгийн автомашины засвар үйлчилгээнд 7.5 сая төгрөг буюу нийт 448.1 сая төгрөг зарцуулахаар баталж, хэрэгжүүлсэн байна

Хонгор сумын Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний зураг төсөв эцэслэж шийдвэрлэгдээгүй байхад дараах ТАХ-г ИТХ-аар батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹², Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тогтоолоор баталсан журмын 4.3.3¹³ заасантай тус тус нийцэхгүй байна.

Хонгор сумын ОНХС

- Хүйтний голын гүүр шинэчлэн, засварлахад 200.0 сая төгрөг,
- Мал нядалгааны газар байгуулахад 800.0 сая төгрөг,

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан шаардлага, нөхцөлд нийцүүлэн баталж байх шаардлагатай байна.

1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгажээ.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 45,306.7 сая төгрөгийн 309 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 22,700.8 сая төгрөгийн 210 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Төлөвлөсөн ТАХ нь холбогдох хууль, журамд заасан арга

¹⁰ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

¹¹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухай орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

¹² Хөрөнгө оруулалтын төсөөт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.


¹³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөө, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх

хэмжээ, чиг үүрэгт хамаарч байгаа эсэхийг шалгахад Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалт, чиг үүрэгтэй нийцсэн байна.

Төлөвлөсөн ТАХ-г журамд заасан чиг үүргийн төрлөөр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл №2: ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ

(Тоогоор, сая.төг)



Энэ нь Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалт, чиг үүрэгтэй нийцсэн байна.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримталж ажиллажээ.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ээс 15,352.5 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 2,643.8 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар шалгаруулж, 1,964.1 сая төгрөгийн 137 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулжээ.

Худалдан авах ажиллагааг Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ТБОНӨХБАҮХАТ хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹⁴ дэх хэсэгт зааснаар тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд байршуулсан байна. Үүнд:

Хүснэгт №6: Тендер шалгаруулалтын байдал

№	ХАА-д мөрдсөн журам	ТАХ-ний тоо	Батлагдсан төсөв /сая.төг/
Дархан-Уул аймаг			
1	Нээлттэй тендер шалгаруулалт	11	6,117.0
2	Харьцуулалтын арга	12	963.0
3	Шууд гэрээ	9	100.6
Дархан сум			
1	Нээлттэй тендер шалгаруулалт	7	2,937.3
2	Харьцуулалтын арга	4	347.2
3	Шууд гэрээ	56	815.7
Хонгор сум			
1	Нээлттэй тендер шалгаруулалт	9	4,213.3
2	Харьцуулалтын арга	7	483.9
3	Шууд гэрээ	37	620.0
Шарын гол сум			
1	Нээлттэй тендер шалгаруулалт	6	1,455.6
2	Харьцуулалтын арга	9	634.2
3	Шууд гэрээ	24	295.6
Орхон сум			
1	Нээлттэй тендер шалгаруулалт	3	629.3
2	Харьцуулалтын арга	5	215.5
3	Шууд гэрээ	11	132.2
	Нийт дүн	210	19,960.4

Эх сурвалж: Аймаг, сумын ХААГ-ын тайлангаас

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 210 ТАХ-ээс 6 ТАХ нь оролцогч ирээгүй буюу худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон бол 2 ТАХ-ны худалдан авах ажиллагааг зарлаагүй байна.

Энэ нь ИТХ-аар зураг, төсөв эцэслэж дуусаагүй төсөл, арга хэмжээ батлуулсан, жилийн эцэст хийсэн тодотголоор шинэ төсөл, арга хэмжээ нэмж төлөвлөсөн зэргээс шалтгаалжээ.

¹⁴ 18.1. Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана.

Тайлант хугацаанд Хонгор сумын Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг, төсөв эцэслэж шийдвэрлэгдээгүй байхад Хонгор сумын хүйтний голын гүүр засвар, шинэчлэл, мал нядалгааны газар байгуулахаар ИТХ-аар батлуулсан нь худалдан авах ажиллагаа хойшлоход нөлөөлсөн байв.

Энэ нь тухайн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, он дамжин хэрэгжих, төсөвт өртөг нэмэгдэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангагдахгүй байх суурь шалтгаан болжээ.

Иймд хуульд заасны дагуу батлагдсан зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй төсөл, арга хэмжээг баталж, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3¹⁵ дэх заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Төлөвлөсөн төсөл арга хэмжээнээс нийт 85.5 сая төгрөгийн 2 ТАХ-г төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулахгүйгээр шууд гэрээ байгуулжээ. Үүнд:

- Орхон сумын төвийн хороолол доторх замыг хатуу хучилттай болгон засварлах 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зураг төсөв,
- Орхон суманд 2025 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах 55.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд байна,

Энэ нь төсвийн захирагч худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹⁶-д заасан ил тод, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг баримтлаагүйгээс гадна Засгийн газрын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 1.3¹⁷ дэх заалтыг мөрдөж ажиллаагүй болохыг харуулж байна.

Тендерт 6 компани үнэлгээний хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй Сангийн яаманд гомдол гаргасныг хянаж шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Дархан сумын 22 дугаар цэцэрлэгийн дээвэр засварын ажлын тендерт оролцсон “Нар сар газар” ХХК,
- Дархан сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад угаалгын тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт оролцсон “Онцот баян хайрхан” ХХК,
- Орхон сумын хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтын тендерт оролцсон “Энержи бөх бат” ХХК,
- Орхон суманд дизель түлшээр ажилладаг цахилгаан үүсгүүр худалдан авах тендерт оролцсон “И Ти Би” ХХК,
- Дархан-Уул аймгийн Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа нийлүүлэх тендерт оролцсон “Баялаг өөдөс” ХХК,
- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах тендерт оролцсон “Газар дэлхий” ХХК-иудын гомдлыг тус тус хянан үзэж хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2¹⁸, 59.10.3¹⁹ дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин үнэлгээ хийхийг мэдэгдсэн байна.

¹⁵ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

¹⁶ Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

¹⁷ Захиалагч хууль болон бусад эрх бүхий этгээдээс баталсан төсвийн дагуу тухайн жилийн төсөвт батлагдсан бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, тайлагнах ажиллагааг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) (цаашид “цахим систем” гэх)-ээр хөтөлнө.

¹⁸ зөрчлийг арилган, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгах;

¹⁹ тухайн асуудалд хуулийн ямар заалт хэрэглэхийг заах.

Үнэлгээний хороод тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийж 4 төсөл, арга хэмжээг өмнөх шалгарсан компаниар, 2 төсөл, арга хэмжээг гомдол гаргасан компаниар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн байна.

2.1.2. Гэрээнд заасан тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй байхад Дархан сумын ОНХС-аас 16.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компанид олгожээ.

Сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4²⁰, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэг, үндсэн нөхцөлийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-нд зарцуулахаар зохицуулсны дагуу Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 27,708.6 сая төгрөгийн 309 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталжээ.

Баталсан төсөл арга хэмжээний 22,605.8 сая төгрөгийн 99 нь шилжиж ТАХ, 22,700.8 сая төгрөгийн 210 нь шинээр хэрэгжүүлэх ТАХ байна. Тухайн онд бүрэн хэрэгжүүлсэн 252 ТАХ-нд 17,326.8 сая төгрөг, дутуу хэрэгжүүлсэн 24 ТАХ-нд 1,890.5 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Баталсан ТАХ-ний хэрэгжилт 89.3 хувь буюу бүрэн хэрэгжсэн 252, дутуу хэрэгжсэн 24, огт хэрэгжээгүй 33 ТАХ байна.

Хүснэгт №7: Хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт

№	Аймаг, сумын ОНХС	Хөрөнгө оруулалт, ТАХ тоо	Олгосон санхүүжилт /сая.төг/
1	Аймаг	72	6,846.2
2	Дархан сум	76	4,381.2
3	Хонгор сум	69	4,908.2
4	Шарын гол сум	41	2,057.2
5	Орхон сум	18	1,024.5
	Нийт дүн	276	19,217.4

Дархан-Уул аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 9,557.1 сая төгрөгийн 89 төсөл, арга хэмжээнээс худалдан авах ажиллагаанд шаардлага хангасан оролцогч ирээгүй 1, оны сүүлээр тодотголоор батлагдсан 1, өмнөх оноос шилжиж ирсэн чанарын баталгаа чөлөөлөх хүсэлт ирээгүй

10, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний зураг төсөв 5, нийт 17 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Харин сумдын хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 18,374.6 сая төгрөгийн 220 төсөл, арга хэмжээнээс 16 нь хэрэгжээгүй байна. Үүнд зураг төсөв эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс 2, өмнөх оноос шилжиж ирсэн чанарын баталгаа чөлөөлөх хүсэлт ирээгүй 3, оны сүүлээр тодотголоор баталсан 6, худалдан авах ажиллагаанд шаардлага хангасан оролцогч ирээгүйгээс 5 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 12.0-98.0 хувь нь худалдан авах ажиллагаанд оролцогч ирээгүйгээс захиалагч оны сүүлээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан, ажил оройтож эхэлсэн зэргээс шалтгаалж, гэрээний хэрэгжилт хангагдаагүй тул хугацааг сунгасан байна.

Тухайн орон нутгийн иргэдийн саналыг аваагүй 10 төсөл, арга хэмжээнд 448.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4²¹, 60.3.6²², Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 4.3.2²³-д заасантай нийцэхгүй байна.

²⁰ Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.

²¹ Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

²² Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

²³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухай орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

Мөн төсөл, арга хэмжээний ТЭЗҮ-ийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс зах зээлийн үнээс өндөр үнээр хөрөнгө бэлтгэж, нийт 6.2 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна. Үүнд:

- “Лэд Сити” ХХК-ийн 1,108.3 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Сумын төвийн гэрэлтүүлэг”-ийн тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс 5.2 сая төгрөгөөр илүү төлөвлөж, санхүүжүүлсэн,
- “Эрдэнэ завилаа” ХХК-ийн 18,114.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Дархан сумын 3 дугаар цэцэрлэг”-ийн тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс 1.0 сая төгрөгөөр илүү төлөвлөж, санхүүжүүлсэн байна

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7²⁴, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²⁵, 16 дугаар зүйлийн 16.5.2²⁶-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитаар сумдын ОНХС-аас санхүүжилт олгохдоо ажлын гүйцэтгэл техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавиагүй, хүлээж авах комиссын үүрэг даалгаврын биелэлт зэргийг хянаагүйгээс дутуу, чанаргүй хийсэн ажил, нийлүүлээгүй барааны санхүүжилтийг олгосон зөрчил илэрлээ. Тухайлбал:

Хонгор сумын ОНХС:

- “Софт солар энерги” ХХК-ийн 268.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийн тохижилт”-ын авто машины зогсоол барих ажлыг дутуу гүйцэтгэсэн байхад 3.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
- “Чонос хүч” ХХК-ийн 19.9 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Камержуулалт засварлах” ажлын 32 камерын 20 камер эвдэрч ажиллахгүй болсон;
- “Лэд Сити” ХХК-ийн 1,108.3 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Сумын төвийн гэрэлтүүлэг”-ийн гэрэлтүүлгийн шон дугаарлах, дамжуулагчийн унжилтыг хэмжих, тохируулах, газардуулгын эсэргүүцэл хэмжүүлэх, будах зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр өгсөн комиссын үүрэг даалгаврыг биелүүлээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;

Дархан сумын ОНХС:

- Дархан сумын Засаг дарга, “Шинэчилгээ” НҮТББ-ын хооронд тоног төхөөрөмж нийлүүлэх 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний ерөнхий нөхцөлийн 3.12-д заасны дагуу 16.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон боловч тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй;
- “Өнөр зам” ХХК-ийн гүйцэтгэсэн “Од” сургуулийн “Б” байрны авто замын шинэчлэлийн хүрээнд хийсэн явган хүний зам комисс хүлээж авсаны дараа эвдэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²⁷, 16.5.3²⁸, 16.5.5²⁹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4³⁰, 15 дугаар зүйлийн 15.1.3³¹, 15.2.6³², Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолуудтай тус тус нийцэхгүй байна.

²⁴ Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна”

²⁵ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

²⁶ Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”

²⁷ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²⁸ батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;

²⁹ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

³⁰ хуулиар зөвшөөрөөгүй бусад.

³¹ хэвлэлийн захиалгын төлбөр;

³² байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 97.6 хувьтай байна

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5 ТАХ төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 45,306.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 309 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 252 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр тайлагнасан боловч 1,557.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах төсөл арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Үүнд:

Дархан сумын ОНХС:

- Монгол гэрийн шинэ шийдэл бүхий дулаалга, халаагуур, агааржуулалтын технологийг олон нийтэд таниулах, турших зорилготой “Ice box” төслийн хүрээнд 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан “Шинэчилгээ” НҮТББ гэрээний ерөнхий нөхцөлийн 3.12-т заасан 16.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт авсан боловч гэрээнд заасан тоног төхөөрөмжийг захиалагч талд нийлүүлээгүй;
- “Батзол” ХХК-с “Дархан-Ус суваг” ОНӨХК-д нийлүүлсэн нийт 209.2 сая төгрөгийн тусгай зориулалтын /ундны ус зөөврийн/ 2 тээврийн хэрэгсэл нь зориулалтын бус, хөлдөлтөөс хамгаалсан дулаалгаагүй зэрэг тендерийн материалд заасан шалгуурыг хангаагүй;

Хонгор сумын ОНХС:

- “Зулзаагын амралтын бүсэд худаг гаргах” ажлын хүрээнд “Эрдэнэдрийлинг” ХХК-ийн гүйцэтгэсэн нийт 84.4 сая төгрөгийн 2 гүний худгийн нэг нь ус гарахгүй болж, нөгөө нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй цэгт байгуулсан;
- “Сумын төвийн гэрэлтүүлэг” хийх ажлыг 1,108.3 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Лэд Сити” ХХК гэрэлтүүлгийн шон дугаарлах, дамжуулагчийн унжилтыг хэмжих, тохируулах, газардуулгын эсэргүүцэл хэмжүүлэх, будах зэрэг ажлыг хийгээгүй;

Шарын гол сумын ОНХС:

- “Болор Эрхэст Цамхаг” ХХК-ийн гүйцэтгэсэн “Авто зам дагуух гэр хороолол руу ногоон байгууламж, явган зам тавих” ажлын хүрээнд хийгдсэн ногоон байгууламжийн хашаанд 1 метр өндөртэй 40 ширхэг нарс мод тарихаар зураг, төсөвт тусгасан боловч 20-40 сантиметр өндөртэй навчит мод тарьсан;

Энэ нь холбогдох албан тушаалтнууд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тооцоо судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөөгүйгээс гадна гүйцэтгэлд тавих хяналт сул байгааг харуулж байна. Мөн ТАХ он дамжих, үргүй зардал гарах, чанар, ашиглалтын шаардлага хангахгүй байх зэрэг сөрөг үр дагавар үүсгэж байна.


Иймд төсөл, арга хэмжээнээс гарах үр дүн, үр ашгийг урьдчилан нэгтгэн тооцох, хоорондын уялдааг хангах, захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгөх ТАХ 98.0 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 17,326.8 сая төгрөгийн 252 ТАХ-г бүрэн хэрэгжүүлсэн байна. Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний 80.6 хувийг буюу 203 ТАХ-г иргэдийн эрүүл мэнд, соёл, боловсрол, дэд бүтэц, гэрэлтүүлэг, зам гүүр барих, орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиг үүргийн хүрээнд 15,970.9 сая төгрөгийн хөрөнгө оруулж, орон нутгийн хөгжлийг дэмжсэн, иргэд олон нийтийг ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан үр дүнтэй ажил болжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт ТАХ, олгосон санхүүжилтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад төсөл арга хэмжээний тоо 41 буюу 17.4 хувиар, олгосон санхүүжилт 5,999.5 сая төгрөг буюу 45.4 хувиар тус тус өссөн байна.

Дүрслэл №3: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ны 2023-2024 оны харьцуулсан үзүүлэлт



Эх сурвалж: Аймаг, сумдын ЗДТГ

Дээрх дүрслэлээс харахад тайлант онд дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ татах, орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамж, малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах, хамгаалах, тэжээлийн нөөц бэлдэх зэрэг төсөл арга хэмжээний тоо, олгосон санхүүжилт 0.4-1.2 дахин өсжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, сумдад хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний сайн жишээ:

Аймгийн ОНХС:

- Дархан 60 цогцолборт волейболын талбайн ажлыг хийсэн бөгөөд энэ нь хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн.
- Сурагчдын автобус нийлүүлэх төсөл хэрэгжсэнээр сурагчдыг тээвэрлэх тусгай зориулалтын 4 тээврийн хэрэгсэлтэй болсон бөгөөд энэ нь сургуулийн сурагчдын эрүүл ахуй, тав тухтай, аюулгүй байдал бүрдсэн замын хөдөлгөөнд оролцож, сургууль, гэрт нь хүргэх нөхцөл бүрдсэн.

Дархан сумын ОНХС:

- Нийтийн орон сууцны 13 орцыг иргэдийн оролцоотой буюу санхүүжилтийн 30 хувийг иргэдээс, 70 хувийг ОНХС-аас санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна. Энэ нь иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хяналт тавих, оролцоо нэмэгдсэн зэрэг ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

Хонгор сумын ОНХС:


- Дархан-Уул аймгийн Хонгор суманд 2024 оны төсвийн жилд Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сумын төвийн гэрэлтүүлэг төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. Тухайн ажлын хүрээнд Атар, Сансар, Зам хэсгүүдэд нийт 414 лэд гэрэлтүүлгийг байршуулсан бөгөөд Алсын зайн удирдлагын системээр

байршил үл хамааран асааж унтраах тохируулгыг хийсэн нь эрчим хүчний хэрэглээгээ хянах боломжтойгоороо онцлог юм;

- Малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар 19.4 сая төгрөгийн мал үржүүлгийн тоног төхөөрөмж худалдан авсан. Энэ нь Хүнс Хөдөө аж ахуйн газар болон Малын удмын сангийн үндэсний цогцолбортой хамтран Малын өнгөт эхог ашиглан малчдын үхэр сүрэгт үзлэг хийж, хээл шалгах орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж байгаагаараа онцлог юм;

Аудитаар иргэд, олон нийтээс сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар авсан судалгаанд нийт 416 иргэн хамрагдсанаас “**Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд сэтгэл хангалуун байна уу?**” гэсэн асуултад 33 хувь нь буюу 137 хүн “**Тийм**” гэж хариулсан бол 14 хувь нь “**хангалтгүй**” гэж хариулжээ.

Дүрслэл №4: Иргэдээс авсан асуулгын дүн



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс эдийн засгийн чадавх, засаглалын болон бизнесийн үр ашиг, дэд бүтэц зэрэг 4 бүлэг шалгуураар хийсэн аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээгээр Дархан-Уул аймаг 2021-2023 онд дараалан 3 дугаарт байрт шалгарсан байна.

Санал асуулгын дүн, аудитын явцад цуглуулсан ажлын баримт, судалгаанаас харахад бүрэн хэрэгжсэн ТАХ-ний 99.6 хувийг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, орон нутгийн хөгжилд үр нөлөө өгөхүйц төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна гэж дүгнэлээ.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна

2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр ТАХ хэрэгжүүлэхдээ хэрэгцээ шаардлага, төслөөс гарах үр дүн, бүрэн ашиглахад шаардлагатай санхүү, хүний нөөцийг тооцоогүйгээс 94.7 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн санхүүжилтээр 36,660.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 252 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.

Аудитаар дээрх ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллага бүрэн ашиглаж байгаа эсэхийг газар дээр нь үзэж шалгахад дараах ТАХ-г зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна. Үүнд:

Дархан сумын ОНХС:

- Зорилтод бүлгийн иргэдийг түр ажлын байраар хангахад чиглэсэн “Кофе шоп” төслийг хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд хийгдсэн 6.2 сая төгрөгийн засвар, 13.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглаагүй байна;

Орхон сумын ОНХС:

- Сумын ЗДТГ-т гамшиг, ослын үед бэлэн байдлыг хангах, цахилгааны нэмэлт эх үүсвэртэй болох зорилгоор дизель түлшээр ажилладаг цахилгаан үүсгүүрийг 27.7 сая төгрөгөөр худалдан авсан боловч холболтын зардлыг төсөвт тусгаж өгөөгүйгээс ашиглалтгүй байна;

Хонгор сумын ОНХС:

- “Эрдэнэдрийлинг” ХХК-ийн “Зулзагын амралтын бүсэд худаг гаргах” ажлын хүрээнд 84.4 сая төгрөгөөр гүйцэтгэсэн 2 гүний худгийн нэг худгаас ус гарахгүй, ашиглалтгүй байна;

Шарын гол сумын ОНХС:

- Шарын гол сумын Засаг дарга, “Атар ирээдүй” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдсэн 18.8 сая төгрөгийн мал үржлийн багаж тоног төхөөрөмжөөс 4.8 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг огт ашиглаагүй байна;

Эдгээр төсөл арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглавал тухайн орон нутагт ажлын байр нэмэгдэх, гамшгийн үеийн бэлэн байдал хангагдах, ундны усан хангамж нэмэгдэх, малын удмын сан нэмэгдэх боломжтой байна.

Иймд сумдын Засаг дарга нар дээрх хөрөнгийг зориулалтаар нь ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээ авч ажиллах зүйтэй юм.

2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглагч байгууллагуудад эзэмшүүлсэн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шарын гол сумын ОНХС:

- "Нарт Оргил Өргөө" ХХК-ийн гүйцэтгэсэн "Шарын гол сумын нэг маягийн сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбайн тохижилтын ажил"-ын хүрээнд хийсэн 1 сандал, 5 хогийн сав эвдэрсэн, сагсны талбайн будаг халцарсан байдалтай байв
- "Тоталсолюшн" ХХК-ийн гүйцэтгэсэн "Сумын доторх авто замын хяналтын камерын засвар, шинэчлэл" ажлын хүрээнд 16 цэгт байршуулсан камерын 10 камер хэвийн ажиллаж байгаа бол 6 камер холболт салснаас ажиллахгүй байлаа;

Орхон сумын ОНХС:

- "Нарсан цамхаг" ХХК-ийн гүйцэтгэсэн Орхон сумын Тосгон Богчийн дэв, Дэлгэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтын 201.4 сая төгрөгийн гэрээт ажлын хүрээнд хийсэн сүлжээний төхөөрөмжийн хүчин чадал муу байгаагаас камер хэвийн ажиллахгүй, тасалдсан байдалтай байлаа;
- "Софт солар энерги" ХХК-ийн гүйцэтгэсэн Орхон сумын өвсний агуулах засварлах 19.8 сая төгрөгийн гэрээт ажлын гүйцэтгэлд биет тулгалт хийхэд том хаалганы бэхлэгээ, 2 талын амлагаа хийгдээгүй байхад комисс хүлээж авсан, мөн дээврээс ус алдсан байдалтай байв;

Энэ нь төсөл арга хэмжээг хүлээн авах комисс ажиллахдаа хариуцлагагүй хандсан, туршилт, зүгшрүүлэлтэд анхаарч ажиллаагүйтэй холбоотой байна.

Иймд нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийн баталгаат хугацаанд засварлуулах, нийлүүлж байгаа хөрөнгийн чанарт анхаарч ажиллаж шаардлагатай байна.

БҮЛЭГ 3: ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

3.1 Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг дутуу хөтлөх зөрчил давтан гарч байна.

3.1.1 Дархан сумын ИТХ “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4³³-т заасан дагуу хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4³⁴-т заасны дагуу Дархан сумын ИТХ-аас бусад байгууллагууд хяналт тавих үүргээ хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн удирдамжаар байгуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ОНХС-аар хэрэгжсэн 32 ТАХ-нд хяналт тавьж, тэмдэглэл хөтлөн үүрэг чиглэл өгч ажилласан байна.
- Хонгор сумын ИТХ-ын 2023 оны 13 дугаар тогтоолоор байгуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын хороо ОНХС-аар хэрэгжсэн 29 ТАХ-нд хяналт тавьж, тэмдэглэл хөтлөн үүрэг чиглэл өгч ажилласан байна.
- Орхон сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн удирдамжийн дагуу 4 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын хороо 12 ТАХ-нд хяналт тавьж тэмдэглэл хөтлөн 10 төсөл арга хэмжээнд үүрэг чиглэл өгч ажилласан байна.
- Шарын гол сумын ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 01-ний удирдамжийн дагуу ОНХС-аар хэрэгжсэн 38 ТАХ-нд хяналт тавьж, 24 арга хэмжээнд зөвлөмж өгч ажилласан байна.

Харин аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2024 онд ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийгээгүй бөгөөд 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөнд аймаг, сумдын ОНХС-г шалгах аар тусгасан байна.

3.1.2. “ДХББЗГ” ОНӨААТҮГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хууль, журмын дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2³⁵-д заасны дагуу захиалагчтай гэрээ байгуулж, гэрээнд заасан хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн ХБТХОХ нь Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамд³⁶ гэж заасны дагуу “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар”

³³ “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

³⁴ “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

³⁵ “Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиглуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно

³⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам

ОНӨААТҮГ-ын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн баримт материалд үндэслэн ТАХ бүрээр хянаж, хүлээн авсан комиссын дүгнэлтээр гүйцэтгэлийн санхүүжилтийг олгожээ.

ТАХ-ний хэрэгжилтэд захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байдлыг тулган шалгахад “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл”-д тухайн цаг үеийн агаарын байдал, өдөр тутам ямар ажлыг хэн, хэн гүйцэтгэсэн талаарх тэмдэглэлийг дутуу хөтөлсөн, инженер даамлаас гүйцэтгэсэн ажлыг шалгаж хүлээн авсан талаар тэмдэглэл хөтлөөгүй, хяналтаар өгсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийн тэмдэглэл хөтөлж, баталгаажуулаагүй дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

- “Түвшингээээ” ХХК-ийн гүйцэтгэсэн “Хатуу хучилттай авто зам /5 дугаар баг үйлдвэрийн хэсэг”-ын 949.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,
- “Өнөр зам” ХХК-ийн гүйцэтгэсэн “Од цогцолборын Б байрны авто замын шинэчлэлт /16 дугаар баг”-ийн 498.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,
- “Ачлалт төмөр хэлхээ” ХХК-ийн гүйцэтгэсэн “Тоглоомын талбай, засвар шинэчлэл /13 дугаар баг, 28 дугаар байр”-ийн 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,
- “Даш зам” ХХК-ийн гүйцэтгэсэн “Сумын төвийн доторх хатуу хучилттай авто зам /тохижилт-6”-ын 990.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, “Салхит багийн дотор зам засвар”-ын 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,
- “Нарт оргил өргөө” ХХК-ийн гүйцэтгэсэн “Шарын гол сумын багуудад хийгдэх нэг маягийн сагсан бөмбөгийн талбай болон тоглоомын талбай” 193.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,
- “Болор эрхэст цамхаг” ХХК-ийн гүйцэтгэсэн “Байрнуудын гаднах авто машины зогсоол нэмэгдүүлэх” 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, “Эрүүл мэндийн төвийн байрны хэсэгчилсэн дотор засвар”-ын 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,
- “Нарсан цамхаг” ХХК-ийн гүйцэтгэсэн “Хорооллын гэрэлтүүлэг, камержуулалт”-ын 248.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудад байна

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.7³⁷-т заасантай нийцэхгүй байна.

3.1.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан ч алдаа, зөрчил давтагдан гарч байна.

Өмнөх онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэрийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Тухайлбал нийт 16.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3.4 сая төгрөгийн төлбөрийн акт, чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийлгэх 27.8 сая төгрөгийн 2, хариуцлага тооцох 1, нийт 3 албан шаардлага, 16.1 сая төгрөгийн 22 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг хянахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

³⁷ “Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг бичлэн хянаж, шалгах үүрэг бүхий захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргаж, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн баримт бичгийн хамт захиалагчийн архивд хадгалуулна.

Гэсэн хэдий ч өмнөх аудитаар илэрсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгийн бүртгэл, худалдан авах ажиллагаа, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, засвар шинэчлэл, ашиглалттай холбоотой зөрчил давтагдан гарсан байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журамд заасны дагуу тайлагнасан байна.

Дархан, Хонгор, Шарын гол сумд Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 9.2³⁸, 9.9³⁹-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, мэдээллийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хугацаанд нь тайлагнажээ. Харин Орхон сум хэрэгжилтийн тайланг хугацаа хоцроож, зарим ТАХ-ний мэдээллийг дутуу тайлагнасан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь дээрх журмын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж Сангийн яаманд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1-10/127 тоот албан бичгээр хугацаанд нь хүргүүлжээ.

3.2.2 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн 1,503.5 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд аймгийн ИТХ-ын 2024 оны 13, 24, 26, Хонгор сумын 2024 оны 19, Орхон сумын 2025 оны 05, Шарын гол сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/99, 01-А/143, 01-А/491, А/524 дүгээр захирамжаар нийт 15,248.7 сая төгрөгийн 132 ТАХ-г хөрөнгөд бүртгэх шийдвэр гарчээ.

Аудитаар аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгөд бүртгэх тогтоол болон ашиглагч байгууллагын санхүүгийн тайлантай тулган шалгахад нийт ТАХ-ний 33.0 хувь буюу 6,086.4 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд, 48.0 хувь буюу 8,878.0 сая төгрөгийн хөрөнгийг нийтийн эзэмшлийн хөрөнгөд, 1.5 хувь буюу 284.3 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд, 17.5 хувь буюу 3,228.6 сая төгрөгийг урсгал зардлаар тус тус бүртгэжээ.

Харин 1,503.5 сая төгрөгийн 21 ТАХ-г ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргаагүй, нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.

Хүснэгт №8: Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ТАХ-ний жагсаалт

(сая.төгрөг)

№	Аймаг/ сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Дүн
1	Аймаг ОНХС	Дархан 60 цогцолбор /2 үе шатны ажил/ /Явган зам/	52.3
2		Цахим Дархан хөтөлбөр	295.2
3		Зураг төсөв боловсруулах	0.9
4		Үерийн байгууламж /Инженер геологийн судалгаа, дүгнэлт/ Дархан сум/	45.2

³⁸ “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана”

³⁹ ОНХС-ийн тайланд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

9.9.1 Тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;

9.9.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;

9.9.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;

9.9.4 Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;

9.9.5 Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;

9.9.6 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;

9.9.7 Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга

5		Цэцэрлэгийн барилга, 100 ортой /Инженер геологийн судалгаа, дүгнэлт/Дархан сум/	6.0
6		Өвлийн спортын ордны барилга /Инженер геологийн судалгаа, дүгнэлт/Дархан сум/	12.5
7		Түр саатуулах байр /Инженер геологийн судалгаа, дүгнэлт/ Дархан сум/	6.4
8		Кино павилон /Инженер геологийн судалгаа, дүгнэлт/ Дархан сум/	15.5
9		ГОСТ өрхийн эрүүл мэндийн төв /Инженер геологийн судалгаа, дүгнэлт/ Дархан сум/	5.8
10		Граш болон Зөгийн аж ахуйн барилгын инженер геологийн судалгаа дүгнэлт /Дархан-Уул, Орхон сум/	5.0
11		Цэцэрлэгийн барилга 100 ортой /Дархан сум 15-р баг /	165.0
12		Төв гудамжны засвар, гадна тохижилт, замын засвар	192.8
13	Орхон сум ОНХС	Сумын төвийн хороолол доторх замыг хатуу хучилттай болгон засварлах ажлын зураг төсөв хийлгэх	30.0
14		2025 онд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах ажлын төлбөр	12.7
15	Хонгор сум ОНХС	ЭМТНАРАН ОНӨААТҮГ-ын уурын зуухны шинэчлэл нэмэлт ажил	20.0
16		Тулга сувиллын сувилуулагчдын ор, тумбочек шинэчлэх	13.9
17	Шарын гол сум ОНХС	Нийтийн эзэмшлийн 2 давхар 15ш байр болон 5 давхар 5 блок байрны дээвэр засварын ажил	570.4
18		Соёлын төвийн тайзны гэрэлтүүлэг	15.0
19		Төв замын зогсоолын налууг эко хавтангаар хучих	15.0
20		Ундны усны худаг засвар, хашаажуулалт	14.3
21		Хайрхан багийн задгайд худаг шинээр хийх	9.5
	Нийт		1,503.5

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь ТАГ (ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний бүртгэлийн тулгалт)

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.4.6. "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны дагуу шийдвэрлэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд төрийн өмчийн хөрөнгө эзгүйдэх, үрэгдэх эрсдэлээс сэргийлж, санхүүгийн жилд багтаан нягтлан бодох бүртгэлд тусгуулах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт болон аймгийн Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж хүргүүлэв.

3.2.3 ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг УМС-д бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт үнэн зөв бодитой мэдээллээр хангагдахгүй байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 10⁴⁰-т ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний мэдээллийг бүртгэхээр заасан байна.

⁴⁰ ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем

Дархан-Уул аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн ТАХ-ий гүйцэтгэлийг Удирдлагын мэдээллийн системээр иргэд, олон нийтэд хэрхэн ил тод, нээлттэй мэдээлсэн эсэхэд хяналт тавьж, тулган баталгаажуулахад нийт 309 төсөл арга хэмжээнээс 167 ТАХ-г бүрэн мэдээлсэн бол 104 ТАХ-г дутуу, 38 ТАХ-г системд огт оруулаагүй байлаа.

Дүрслэл №5: УМС-д мэдээлэл оруулсан байдал (ТАХ-ны тоо)



Эх сурвалж: onhs.mof.gov.mn

Дээрх дүрслэлээс харахад нийт хөтөлбөр, төсөл арга хэмжээний 45.9 хувийг дутуу болон огт оруулаагүй байгаа нь албан тушаалтнууд журамд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй байх, иргэд, олон нийт ил тод, үнэн зөв, бодитой мэдээллээр хангагдахгүй байх үр дагавар үүсэж байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.2⁴¹, 10.3.3⁴² дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд аймаг, сумдын Засаг дарга нар Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмыг 10 дахь хэсгийн 10.2⁴³-т заасны дагуу системд оруулах шаардлагатай мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулсан эсэхэд хяналт тавьж, оруулсан мэдээлэлд үндэслэн санхүүжилтийг олгож байх шаардлагатай байна.

3.2.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ОНХС-ийн орлогын 2,218.0 сая төгрөгийн 11 гүйлгээ, зарлагын 261.3 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан эсэхийг 2024 оны байдлаар шалгаж, дүн шинжилгээ хийхэд аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 19,217.3 сая төгрөгийн 276 хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

⁴¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ;

⁴² ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохогүй;

⁴³ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ.

Харин Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цалингий зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ цэсэд *Шарын гол сумын ОНХС-гийн орлогын 2,218.0 сая төгрөгийн 11 гүйлгээ, зарлагын 261.3 сая төгрөгийн 3 гүйлгээ* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.

Шилэн дансны цахим хуудаст санхүүжилтийн орлого болон ТАХ-ний зарцуулалтыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1¹, 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасантай тус тус нийцэхгүй байна. Энэ нь хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, иргэд, олон нийт, үнэн зөв, иж бүрэн, бодитой мэдээллийг олж авахгүй байх үр дагавар үүсэж байна.

Цаашид аудитаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, тогтоосон хугацаанд мэдээллийг үнэн зөв, тогтмол, шуурхай мэдээлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шаардлагатай байна.



ДҮГНЭЛТ:

Аудитаар нийт 2,771.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9.7 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, зөрчил арилгуулах тухай 105.5 сая төгрөгийн 11 албан шаардлага хүргүүлэн, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 2,655.9 сая төгрөгийн 19 зөвлөмж өглөө.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ОНХНС-аас аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож гаргасан боловч 739.7 сая төгрөг дутуу олгосон байна.
- ОНХС-ын орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө өмнөх оны үлдэгдэл, малын тоо толгойн татварын орлогыг санхүүжилтийн эх үүсвэрт тусган батлуулсан байна.
- ОНХСанд санал өгсөн иргэдийн дундаж хувь улсын дунджаас 23.8 хувиар бага үзүүлэлттэй гарахад Дархан, Орхон сумдын санал өгсөн иргэдийн дундаж хувь нөлөөлсөн байна.
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх зөрчил давтагдан гарсаар байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр дутуу болон хэрэгжээгүй төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжсэнээр тайлагнасан байна.
- Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтийн 91.1 хувийг дэд бүтэц, орчны тохижилт зэрэг орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгөх ТАХ-нд зарцуулсан байна.
- ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн 94.7 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй байна.
- Дархан сумын ИТХ “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4⁴⁴-т заасан дагуу хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг УМС-д бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт үнэн зөв бодитой мэдээллээр хангагдахгүй байна
- Шилэн дансны цахим системд мэдээллээ дутуу байршуулах зөрчил давтагдан гарсаар байна.
- Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 1,503.5 сая төгрөгийн 21 ТАХ-г ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргаагүй, нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй нь өмч хөрөнгө эзгүйдэх, үрэгдэх эрсдэлтэй байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан ч алдаа, зөрчил давтагдан гарч байна

⁴⁴ “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Дархан сумын ИТХ-ын дарга Б.Эрдэнэзаяа танаа

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4⁴⁵-т заасны дагуу хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх

Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа танаа

1. ОНХС-д санал өгөх иргэдийн тоог нэмэгдүүлэх
2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2-д заасны мөрдөж иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ-г төлөвлөж, санхүүжүүлэхгүй байх
3. Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож байх
4. Техникийн тодорхойлолт, шаардлагыг хангаагүй машин, тоног төхөөрөмжийг хүлээн авахгүй байх
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Кофе шоп” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног, төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх

Хонгор сумын Засаг дарга Н.Ганбаатар танаа:

1. Зураг, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг батлуулахгүй байх
2. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 20.0 сая төгрөгийн 1 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгуулах
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны төлөвлөлт, хэрэгжилт, зарцуулалт, үр дүнгийн талаар УМС-д бүрэн оруулж байх

Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт танаа:

1. ОНХС-д санал өгөх иргэдийн тоог нэмэгдүүлэх
2. ОНХС-ийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн дизель цахилгаан үүсгүүрийг ашиглалтад оруулж, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах
3. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор хугацаанд нь иж бүрэн тайлагнаж байх
4. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 235.5 сая төгрөгийн 3 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгуулах
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны төлөвлөлт, хэрэгжилт, зарцуулалт, үр дүнгийн талаар УМС-д бүрэн оруулж байх

Шарын гол сумын Засаг дарга М.Мөнхбаяр танаа:

1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын

⁴⁵ “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

- 4.3.2-д заасны мөрдөж мөрдөж иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ-г төлөвлөж, санхүүжүүлэхгүй байх
2. ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн мал үржлийн багаж, тоног төхөөрөмжийг зориулалтаар нь ашиглах
3. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 638.2 сая төгрөгийн 6 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгуулах
4. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллээ хугацаанд нь бүрэн байршуулж байх
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны төлөвлөлт, хэрэгжилт, зарцуулалт, үр дүнгийн талаар УМС-д бүрэн оруулж байх

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Бат-Эрдэнэ танаа:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 609.8 сая төгрөгийн 11 ТАХ-г орон нутгийн өмчид бүртгэх

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дарга Д.Батбаяр танаа

1. "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.7-т заасан хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар түүний биелэлтийн талаар тэмдэглэл хөтөлж ажиллах

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁴⁶-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2025.07.07

⁴⁶ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

